



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/21/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: Erdenechimegg@audit.gov.mn

Аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	3-8
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлийн тайлан	4
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	4-5
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5-6
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9-12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12-14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18



ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГА Н.АНХБАЯР
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цэцэрлэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Цэцэрлэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч төсөв, санхүүгийн хувьд Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх, үүрэг хэрэгжүүлэхээс гадна Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1 дэх зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

Цэцэрлэг сумын засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 140 зорилт, 212 арга хэмжээний хэрэгжилт 70.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,063,735.1	1,687,786.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	255,815.8	744,226.9
33	АВЛАГА	165,900.8	163,707.4
34	УРЬДЧИЛГАА	766.7	300.0
35	БАРАА МАТЕРИАЛ	641,251.8	779,552.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,591,230.5	9,706,815.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	65,297.9	51,725.7
37300	Урт хугацаат зээл	65,297.9	51,725.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,525,932.6	9,655,089.8
39200	Биет хөрөнгө	9,308,694.8	9,443,977.1
39300	Биет бус хөрөнгө	217,237.8	211,112.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,654,965.6	11,394,602.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,483.8	14,871.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,483.8	14,871.6
41300	Өглөг	13,483.8	14,871.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,641,481.8	11,379,730.3
51	Засгийн газрын хувь оролцоо	10,641,481.8	11,379,730.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,944,816.4	2,950,456.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,727,328.4	3,790,857.0
51200	Хуримтлагдсан үр дүн	1,743,955.4	2,406,590.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,225,381.7	2,231,826.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,654,965.6	11,394,602.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,381,001.2	5,204,532.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	165,617.5	325,187.2
110	Орлогын албан татвар	70,250.9	136,608.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	70,250.9	136,608.8
113	Хөрөнгийн албан татвар	1,904.0	75,230.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	93,462.6	113,348.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,339,729.7	666,625.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,339,729.7	666,625.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,875,653.9	4,212,720.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,033,324.8	4,493,790.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,033,324.8	4,493,790.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,799,462.6	4,365,707.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,218,501.0	2,337,083.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	285,502.8	306,404.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,323.0	100,326.7
2104	Хангамж, бараа материалын зардал	169,894.4	161,213.8
2105	Нормативт зардал	145,968.1	537,002.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,822.7	26,913.1
2107	Томилолт, зочны зардал	3,630.7	6,007.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,455.0	95,997.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	758,364.9	794,758.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	233,862.2	128,082.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,347,676.4	710,742.3

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	51,516.9	84,548.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,296,159.5	626,193.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,348,442.1	0.0	9,348,442.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,893.1	0.0	6,893.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,355,335.2	0.0	9,355,335.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-12.9	0.0	-12.9
8	Зарласан ногдол ашиг	-10,000.0	0.0	-10,000.0
9	Тайлант үеийн үр дүн	1,296,159.5	0.0	1,296,159.5
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,641,481.8	0.0	10,641,481.8
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,641,481.8	0.0	10,641,481.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	36,441.8	0.0	36,441.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,677,923.5	0.0	10,677,923.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-34,708.3	0.0	-34,708.3
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	5,640.0	0.0	5,640.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	104,681.4	0.0	104,681.4
19	Тайлант үеийн үр дүн	626,193.7	0.0	626,193.7
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,379,730.3	0.0	11,379,730.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,117,736.7	4,630,044.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	165,617.5	325,187.2
110	Орлогын албан татвар	70,250.9	136,608.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	70,250.9	136,608.8
113	Хөрөнгийн албан татвар	1,904.0	75,230.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	93,462.6	113,348.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,850.0	8,090.8
1181	Газрын төлбөр	873.8	1,657.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	83,738.7	103,599.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,465.3	141,060.2
120	Нийтлэг татварын бус орлого	76,465.3	141,060.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,875,653.9	4,163,797.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,706,680.3	3,833,582.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,706,680.3	3,833,582.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,472,818.2	3,705,500.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,357,818.8	2,491,113.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327,035.6	354,753.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,827.3	121,711.2
2104	Хангамж, бараа материалын зардал	285,151.3	278,848.8
2105	Нормативт зардал	192,824.7	230,622.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,834.0	37,000.0
2107	Томилот, зочны зардал	3,661.9	6,007.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,883.5	80,529.1

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,781.1	104,914.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	233,862.2	128,082.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	411,056.4	796,462.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	321,840.9	308,051.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	321,840.9	308,051.0
2200	Дотоод эх үүсвэрээр	321,840.9	308,051.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-321,840.9	-308,051.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	89,215.4	488,411.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	166,600.4	255,815.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	255,815.8	744,226.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,214,998.4	3,702,626.7	512,371.7	87.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,667,721.0	3,582,126.7	85,594.3	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,610,352.9	3,528,840.8	81,512.1	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,253,430.6	2,227,335.3	26,095.3	98.8
210101	Үндсэн цалин	1,592,277.8	1,600,701.2	(8,423.4)	100.5
210102	Нэмэгдэл	509,361.8	478,798.5	30,563.3	94.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,960.0	8,269.2	690.8	92.3
210104	Урамшуулал	135,217.9	133,894.7	1,323.2	99.0
210105	Гэрээт ажлын хөлс	7,613.1	5,671.6	1,941.5	74.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	305,727.4	298,953.7	6,773.8	97.8
210201	Тэтгэврийн даатгал	215,827.6	210,217.6	5,610.0	97.4
210202	Тэтгэмжийн даатгал	22,475.0	22,286.9	188.1	99.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,979.8	17,750.3	229.5	98.7
210204	Ажилгүйдлийн даатгал	4,494.9	4,440.1	54.8	98.8
210205	Эрүүл мэндийн даатгал	44,950.1	44,258.8	691.3	98.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	453,456.8	449,095.3	4,361.5	99.0
210301	Гэрэл, цахилгаан	21,243.4	18,302.4	2,941.0	86.2
210302	Түлш, халаалт	415,395.7	414,430.0	965.7	99.8
210303	Цэвэр, бохир ус	16,817.7	16,362.9	454.8	97.3
210304	Байрны түрээс	-	-	-	#DIV/0!
2104	Хангамж, бараа материалын зардал	150,892.9	145,381.3	5,511.6	96.3
210401	Бичиг хэрэг	10,997.9	11,319.4	(321.5)	102.9
210402	Тээвэр, шатахуун	80,220.2	78,739.7	1,480.5	98.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,576.2	9,237.3	2,338.9	79.8
210404	Ном, хэвлэл	2,032.0	1,622.7	409.3	79.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,065.0	3,797.2	267.8	93.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,001.6	40,665.0	1,336.6	96.8
2105	Норматив зардал	140,762.9	136,226.0	4,536.9	96.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,901.0	30,289.7	611.3	98.0
210502	Хоол, хүнс	104,011.9	102,137.0	1,874.9	98.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,850.0	3,799.3	2,050.7	64.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	192,454.1	174,653.2	17,800.9	90.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	81,681.4	81,371.4	310.0	99.6

210602	Тавилга	70,348.0	67,125.0	3,223.0	95.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500.0	2,200.0	300.0	88.0
210604	Урсгал засвар	37,924.7	23,956.8	13,967.9	63.2
2107	Томилолт, зочны зардал	6,135.9	5,213.7	922.2	85.0
210702	Дотоод албан томилолт	6,135.9	5,213.7	922.2	85.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,383.8	19,735.8	5,648.0	77.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,902.5	13,559.2	3,343.3	80.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,365.0	1,450.0	915.0	61.3
210803	Даатгалын үйлчилгээ	470.0	239.5	230.5	51.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	590.0	273.0	317.0	46.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	260.0	42.8	217.2	16.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450.0	450.0	-	100.0
210807	Газрын төлбөр	2,846.3	2,639.4	206.9	92.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500.0	1,081.9	418.1	72.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,108.5	72,246.6	9,861.9	88.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,354.7	21,437.4	8,917.3	70.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,753.8	50,809.2	944.6	98.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,368.1	53,285.9	4,082.2	92.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,368.1	53,285.9	4,082.2	92.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500.0	500.0	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,694.3	43,686.6	4,007.7	91.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,253.8	5,253.8	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,920.0	3,845.5	74.5	98.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	496,527.4	120,500.0	376,027.4	24.3
223001	Бусад хөрөнгө	496,527.4	120,500.0	376,027.4	24.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,750.0	-	50,750.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	50,750.0	-	50,750.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,214,998.4	4,009,759.1	205,239.3	95.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,921,524.9	2,896,073.4	25,451.5	99.1
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,606,654.7	2,581,203.2	25,451.5	99.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	314,870.2	314,870.2	-	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,020,007.6	994,139.9	25,867.7	97.5
320001	Орон нутгийн төсвөөс	1,020,007.6	994,139.9	25,867.7	97.5
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,609.2	36,567.5	9,041.7	80.2
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	45,609.2	36,567.5	9,041.7	80.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	227,856.7	82,978.3	144,878.4	36.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.0	77,368.8	(27,368.8)	154.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500.0	5,609.5	(4,109.5)	374.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	176,356.7	-	176,356.7	-

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	143,458.3	(143,458.3)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	450,590.7	(450,590.7)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,404	1,197	207	85
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8	-	100
610001	Төсвийн байгууллага	8	8	-	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	189	189	-	100
620001	Удирдах ажилтан	17	17	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	106	106	-	100
620003	Үйлчлэх ажилтан	66	66	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	348,214.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,214.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	298,869.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,213.0
210101	Үндсэн цалин	103,463.0
210104	Урамшуулал	7,750.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,061.0
210201	Тэтгэврийн даатгал	9,061.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	304.3
210302	Түлш, халаалт	304.3
2104	Хангамж, бараа материалын зардал	12,105.6
210401	Бичиг хэрэг	813.3
210402	Тээвэр, шатахуун	3,006.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	65.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,491.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,729.0
2105	Нормативт зардал	94,396.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,758.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,638.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	980.0
210604	Урсгал засвар	980.0
2107	Томилолт, зочны зардал	794.0
210702	Дотоод албан томилолт	794.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,886.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,886.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,128.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,213.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,915.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,345.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,345.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,145.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	348,214.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	348,214.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,162.1
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	113,413.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,207.1
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	192,431.9

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Н.Анхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд гарсан зөрчил, дотоод хяналт, орлого бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт Цэцэрлэг сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 51 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэцэрлэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Олон нийтийн оролцоонд тулгуурласан, ил тод хариуцлагатай засаглалтай иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг эрхэмлэн, сумын хөгжил дэвшлийг оновчтой бодлогоор хангана” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон хэдий ч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдсэн хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна.

ТТЗ-ийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт хангалтгүй байна.

Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/56 дугаар тоот захирамжаар сумын орон тооны бус дотоод аудитын нэгжийг 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Тайлант онд дараах чиглэлээр хяналтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
- Орон нутгийн орлого бүрдүүлэлт

- Цалин олголт
- Хүүхдийн цэцэрлэгийн НДШ төлөлт
- Эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт
- Шатахууны зарцуулалт
- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалт
- Нэрлэсэн жил хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хяналтаар илэрсэн алдаа зөрчилд нийт 15 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад өгсөн бөгөөд хэрэгжилтийг тооцоож дүр дүнг үнэлээгүй байна. Цаашид илэрсэн зөрчилд хугацаатай зөвлөмжийг өгч хэрэгжилтийг тооцож ажиллах нь зүйтэй байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,033.3 сая төгрөгийн 2.0 хувь буюу 80.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 64.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 255.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 744.2 сая төгрөг болж 488.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	246.3	720.9	474.7
Арилжааны банкин дахь үлдэгдэл	9.5	23.3	13.8
Дүн	255.8	744.2	488.4
Үүнээс: Байгууллагаар харуулбал			
Орон нутгийн ерөнхий орлого	95.2	262.7	167.5
Орон нутгийн хөгжлийн сан	106.7	331.0	224.4
Сум хөгжүүлэх сан	36.8	119.6	82.8
Байгаль хамгаалах сан	7.6	7.6	0.0
Тэсийн-Илч ХХК	9.5	23.3	13.8

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 720.9 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 23.3 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдсэн нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 11 тендер шалгаруулалтад оролцогч ААН байгууллагууд материалаа ирүүлээгүйтэй холбоотой тус төсөл арга хэмжээнүүд хэрэгжээгүй, тайлант онд СХС-аас иргэдэд зээл олгоогүй зэргээс шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд харьяа байгууллагуудад олгосон 1,575.1 сая төгрөгийн санхүүжилтийн гүйлгээг орлого, зарлага талд нь устгаж цэвэр дүнгээр нь нэгтгэн тайлагнасан байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ байхгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 165.9 сая төгрөг байснаас 163.7 төгрөг болж 2.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлага /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт/+, -/
Засаг даргын Тамгын газар	15.7	19.1	3.5
Сум хөгжүүлэх сан	131.0	15.5	-115.5
Тэсийн-Илч ХХК	19.3	15.5	-3.8
Эрүүл мэндийн төв	0.0	66.5	66.5
Хүүхдийн цэцэрлэг	0.0	0.3	0.3
Нийт дүн	165.9	163.7	-2.2

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь шүүхээр тогтоогдож ажилдаа эргэн орсон албан хаагчийн ажилгүй байсан хугацааны тэтгэмжийг ЗДТГ-ын төсвөөс олгосон байна. ЗДТГ-ын төсвөөс олгосон мөнгийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаас авах авлага үүсгэснээр авлага 3.5 сая төгрөгөөр нэмэгдсэн. Авлага барагдуулах арга хэмжээг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 25 иргэнтэй холбоотой 57.3 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Эрүүл мэндийн төвийн төлбөртэй үйлчилгээний авлага 47.5 сая төгрөгөөр, эмийн тооцооны авлага 18.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Авлагын үлдэгдэл буурахад СХС-ийн зээлийн 115.5 сая төгрөгийн авлага барагдсан нь нөлөөлсөн байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилаа дансны эхний үлдэгдэл 0.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 0.3 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа /сая төгрөг/.

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тэсийн-Илч ХХК	0.7	0.3	-0.4
Нийт дүн	0.7	0.3	-0.4

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тэсийн-Илч ХХК нь өмнөх оны урьдчилгаа дансны үлдэгдлийн тооцоог барагдуулсан бөгөөд тайлант онд хогны машины сэлбэг авахаар урьдчилж төлсөн 0.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

3.5.5 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 641.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 779.5 сая төгрөг

болж 138.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засаг даргын Тамгын газар	57.3	100.7	43.4
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2.7	2.1	-0.6
Соёлын төв	11.1	10.2	-0.9
Ерөнхий боловсролын сургууль	253.3	277.7	24.5
Хүүхдийн цэцэрлэг	98.7	110.0	11.3
Эрүүл мэндийн төв	75.7	115.0	39.4
Могой цэцэрлэг	38.9	42.5	3.6
Могойн бага сургууль	47.1	53.7	6.6
Могойн эмнэлэг	16.5	11.0	-5.6
Тэсийн-Илч ХХК	40.0	56.6	16.6
Нийт дүн	641.3	779.6	138.3

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь Эрүүл мэндийн төвийн эм эмнэлгийн хэрэгслийн материалын үлдэгдэл нэмэгдсэн, Тэсийн-Илч ХХК нь 2022 оны эхний хагас жилийн нүүрсний татан авалтыг хийсэнтэй холбоотой байна.

3.5.6. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Хүснэгт №5 Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Сум хөгжүүлэх сан	65.3	51.7	-13.6
Нийт дүн	65.3	51.7	-13.6

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн урт хугацаат зээлийн авлагын эхний үлдэгдэл 65.3 сая төгрөг эцсийн үлдэгдэл 51.8 сая төгрөг болж 13.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,525.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,655.1 сая төгрөг болж 129.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Засаг даргын Тамгын газар	2,174.7	2,169.0	(5.7)
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	5.8	6.0	0.2
Соёлын төв	192.6	193.9	1.2
Ерөнхий боловсролын сургууль	1,202.8	1,396.6	193.7
Хүүхдийн цэцэрлэг	1,552.7	1,578.5	25.8
Эрүүл мэндийн төв	467.4	517.1	49.8
Могой цэцэрлэг	216.0	209.8	(6.1)
Могойн бага сургууль	279.1	328.4	49.4
Могойн эмнэлэг	112.9	106.2	(6.7)
Тэсийн-Илч ХХК	3,322.0	3,149.5	(172.5)
Нийт дүн	9,525.9	9,655.1	129.2

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө нэмэгдсэн шалтгаан нь ЕБС, Могойн бага сургуулийн багш хөгжлийн төвийг тохижуулсан, Эрүүл мэндийн төвд нутгийн зөвлөлөөс авто машин хандивласан, хүүхдийн цэцэрлэгт боловсролын яамнаас тоног төхөөрөмж нийлүүлсэн зэргээр нэмэгдсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн 76.5 сая төгрөгийн хөрөнгийг Сумын ИТХ-ын 06 дугаар тогтоолоор ЗДТГ-т шилжүүлэн бүртгэсэн зэргээр нэмэгдсэн байна.

Тайланд онд үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгүүдийг Аймгийн ИТХТ-ийн 2021.12.21-ны өдрийн 111 дугаар тогтоолоор эд хөрөнгийн ашиглалтын хугацаа өртгийг шинэчлэн тогтоож 306.1 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэ тогтоож орлого авснаар үндсэн хөрөнгө нэмэгдэх байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 13.8 төгрөг, эцсийн үлдэгдэл 14.9 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Байгаль хамгаалах сан	7.6	7.6	-
Тэсийн-Илч ХХК	4.4	6.6	2.2
Могойн эмнэлэг	1.5	-	(1.5)
Хүүхдийн цэцэрлэг	-	0.7	0.7
Нийт дүн	13.8	14.9	1.0

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдэл өссөн шалтгаан нь Тэсийн-Илч ХХК нь НӨАТ-ын тооцооллыг буруу хийсний улмаас НӨАТ-ын 6.6 сая төгрөгийн өглөг үүссэн, Могойн эмнэлэг ХХОАТ-ын 1.5 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан зэрэг нь нөлөөлсөн байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 10,641.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 11,379.7 сая төгрөг болж 738.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,944.8	2,950.5	5.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,727.3	3,790.9	63.6
Хуримтлагдсан үр дүн	1,744.0	2,406.6	662.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,225.4	2,231.8	6.4
Нийт дүн	10,641.5	11,379.7	738.2

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант оны үр дүн болон төрийн өмчийн дүнгээр нэмэгдсэн байна. Засгийн газрын сан нэмэгдсэн нь Соёлын төв нь 5.7 сая төгрөгийн газрыг орлого авснаас шалтгаалсан байна.

3.5.10 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 5,381.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 176.5 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна.

Хүснэгт №9 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	165.6	325.2	159.6	196.3
Татварын бус орлого	1,339.7	666.6	(673.1)	49.8
Тусламж санхүүжилтийн орлого	3,875.7	4,212.7	337.1	108.7
Нийт дүн	5,381.0	5,204.5	(176.5)	96.7

Нийт орлогын дүн буурахад үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө өмнөх оноос 946.1 сая төгрөгөөр бага байгаа нь орлогын дүн буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,649.6 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5.11 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 4,578.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №10: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,033.3	4,493.8	460.5	111.4
Үйл ажиллагааны бус зардал	51.5	84.5	33.0	164.1
Нийт дүн	4,084.8	4,578.3	493.5	112.1

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь цалингийн урамшууллын зардлын дүн 118.6 сая төгрөгөөр, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэглэлийн зардал 374.2 сая төгрөгөөр нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,649.6 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяа байгууллагуудын төсвийн саналыг нэгтгэн боловсруулж дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Цэцэрлэг сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт 43 арга хэмжээнд зориулан 4,062.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3,602.8 сая төгрөгийг урсгал зардалд, 458.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,551.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 428.4 сая төгрөгийг ОНХС-аас, 826.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 158.5 төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 51.5 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны орлогоос, 45.6 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Цэцэрлэг сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаар дугаар тогтоолоор төсөвт 158.3 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 4,220.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар төсөвт зохицуулалт хийхдээ Ерөнхий боловсролын сургуулийн төсвийг 9.4 сая төгрөгөөр, Могойн цэцэрлэгийг 0.05 сая төгрөгөөр, нэмэгдүүлж, Могойн бага сургуулийн төсвийг 2.1 сая төгрөгөөр, Хүүхдийн цэцэрлэгийн төсвийг 12.8 сая төгрөгөөр хасах зохицуулалтыг тус тус хийсэн байна. Төсөвт зохицуулалт хийснээр батлагдсан төсвийг 4,215.0 сая төгрөг болгон өөрчилсөн байна. Энэ нь ТТЗ-ийн батлагдсан төсөвт зөрүү үүсэх шалтгаан болсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Цэцэрлэг сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаар тогтоолд зааснаар Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 158.7 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 325.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 205.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №11. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	4.5	4.7	(0.2)	105.5
Хөрөнгийн орлого	28.0	39.9	(11.9)	142.4
Хөрөнгө борлуулсны орлого	-	7.2	(7.2)	0.0
Шууд бус орлого	10.8	84.8	(74.0)	785.1
Бууны албан татвар	2.0	2.5	(0.4)	121.7
Малд ногдуулах албан татвар	30.0	72.7	(42.7)	242.5
Улсын тэмдэгтийн хураамж	5.8	4.4	1.4	75.8

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.4	0.5	1.0	33.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5.2	3.2	2.0	61.5
Газрын төлбөр	1.6	1.7	(0.1)	103.6
Ойн нөөц ашигласны төлбөр	25.5	46.4	(20.9)	182.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	25.8	54.6	(28.8)	211.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.6	0.4	0.2	65.7
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.4	2.2	(0.8)	159.6
Хувьцааны ногдол ашиг	10.0	-	10.0	0.0
Торгуулийн орлого	5.5	0.5	5.0	8.6
Түрээсийн орлого	0.4	-	0.4	0.0
Нийт дүн	158.5	325.7	(167.1)	205.4

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Цэцэрлэг сумын орон нутгийн орлого 167.1 сая төгрөгөөр давж биелэхэд хөрөнгийн орлого 11.9 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 7.2 сая төгрөгөөр, Малын албан татвар 42.7 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөр 49.8 сая төгрөгөөр давж биелсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1.4 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.9 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.0 сая төгрөгөөр, Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр, Хувьцааны ногдол ашгийн орлого 10.0 сая төгрөгөөр, Торгуулийн орлого 5.0 сая төгрөгөөр, Түрээсийн орлого 0.4 сая төгрөгөөр нийт 19.9 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 218.2 сая төгрөгөөр төлөвлөж 351.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 133.6 сая төгрөг буюу 61.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	180.2	301.5	121.5
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	12.0	11.3	(0.7)
3	Газрын төлбөр	2.4	5.9	3.5
4	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	19.0	25.8	6.8
5	Зам ашигласны төлбөр	4.1	5.8	1.7
6	Үйлдвэрлэл үйлчилгээний орлого	0.1	1.6	1.5
7	Түрээс	0.5	-	(0.5)
	Нийт дүн	218.2	351.8	133.6

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Орлого давж биелэхэд цалин хөлс түүнтэй адилтгах орлого 121.5 сая төгрөгөөр давж биелсэн нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 232.1 сая төгрөгөөр төлөвлөж 456.5 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 224.4 сая төгрөгөөр буюу 96.7 хувиар давуулан биелүүлсэн байна. .

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	33.7	45.6	12.0
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	76.9	236.1	159.2
3	Ашигт малтмал ашигласны төлбөр	75.4	93.9	18.5
4	Ус бохирдуулсны төлбөр	0.1	-	(0.1)

5	Агаарын бохирдлын төлбөр	6.0	3.5	(2.5)
6	Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/	40.0	77.4	37.4
	Нийт дүн	232.1	456.5	224.4

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Ус бохирдуулсны төлбөрийн орлого 0.1 сая төгрөгөөр, агаарын бохирдлын татварын орлого 2.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 4,215.0 сая төгрөгөөр төлөвлөж, 4,009.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 95.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 51.5 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 83.0 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөр 43 арга хэмжээнд зориулан 4,215.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3,667.7 сая төгрөгийг урсгал зардалд, 496.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 50.8 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр 2,896.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 994.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 36.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 83.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,702.6 сая төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь Сангийн яамнаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 26.1 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 6.8 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 4.4 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 5.5 сая төгрөг
- Норматив зардал 4.5 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал 17.8 сая төгрөг
- Томилолтын зардал 0.9 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 5.6 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 9.9 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 4.1 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 376.0 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын 18 төсөл арга хэмжээнд 458.1 сая төгрөг батлагдсанаас 7 төсөл арга хэмжээнд 120.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сумын Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт 3,702.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 87.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар 20.2 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 113.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 19.2 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 192.4 сая төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөөс 3.0 сая төгрөг нийт 348.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 298.9 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 49.3 сая төгрөгийг нийт 348.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогуудыг удирдамж зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 158.7 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 325.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 105.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар Ерөнхий боловсролын сургууль болон Хүүхдийн цэцэрлэг “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Улс, орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзвэл:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 19.9 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 2.6 сая төгрөгөөр, аймгийн ерөнхий орлогод төвлөрүүлэх орлого 1.2 сая төгрөгөөр тус тус тасалсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим мэдээллийн системд мэдээлбэл зохих мэдээллүүдийг бүрэн мэдээлж ажилласан байна. Аудитаар алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.



3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 13 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 14 санхүүгийн тайлан, нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 8 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт 3, “Хязгаарлалттай” 2 дүгнэлт өгсөн байна. Үүнд:

- Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургууль “Хязгаарлалттай” дүгнэлт
- Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэг “Хязгаарлалттай” дүгнэлт
- Цэцэрлэг сумын ЗДТГ “Зөрчилгүй” дүгнэлт
- Тэсийн-Илч ХХК “Зөрчилгүй” дүгнэлт
- Эрүүл мэндийн төв “Зөрчилгүй” дүгнэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 859.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 247.0 сая төгрөгийн 6 алдааг залруулж 11.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 69.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 63.3 сая төгрөгийн 14 зөвлөмжийг өгсөн байна.

Үүнээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 467.6 сая төгрөгийн 2 зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 19.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах 1 зөвлөмж нийт 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1.4 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.9 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.0 сая төгрөгөөр, Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр, Хувьцааны ногдол ашгийн орлого 10.0 сая төгрөгөөр, Торгуулийн орлого 5.0 сая төгрөгөөр, Түрээсийн орлого 0.4 сая төгрөгөөр нийт 19.9 сая төгрөгөөр тасарсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

ТТЗ-ийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгж нь харьяа байгууллагуудад хяналт шалгалтыг хийж илэрсэн алдаа зөрчилд зөвлөмжийг өгч ажилласан боловч хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Алдаа зөрчлийг арилгах хугацаатай зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг тооцож ажиллах.

3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 859.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 247.0 сая төгрөгийн 6 алдаа залруулж 11.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 69.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 63.3 сая төгрөгийн 14 зөвлөмжийг өгсөн байна. Үүнээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 467.6 сая төгрөгийн 2 зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал										
Цэцэрлэг сумын ТТЗ	3	19.9							3	19.9
Дүн	3	19.9							3	19.9
Харьяа байгууллагуудын зөрчил										
Ерөнхий боловсролын сургууль	4	82.3					2	69.3	2	13.1
Хүүхдийн цэцэрлэг	6	355.7	2	3.6	1	11.9			3	340.2
Эрүүл мэндийн төв	3	103.5	1	103.5					2	
ЗДТГ	6	209.7	2	38.5					4	171.2
Тэсийн-Илч ХХК	4	108.0	1	101.4					3	6.6
Дүн	23	859.2	6	247.0	1	11.9	2	69.3	15	530.9
Нийт дүн	26	879.1	6	247.0	1	11.9	2	69.3	18	550.8



АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО: